



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРАЛ НАРТ

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2019. 07. 05 № 6/6250
танай _____-ны № _____-т

Удирдамж хүргүүлэх тухай

Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэн, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газартай хамтран “Хот суурин газрын гамшгийг тэсвэрлэх чадвар (resilience)-ыг бэхжүүлэх арга зам” сэдэвт олон улсын хурлыг 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулахаар товлосон байна. Хурлын удирдамжийг албан бичгээр ирүүлснийг хавсарган хүргүүлж байна.

Энэхүү олон улсын хуралд эрдэмтэн, судлаачдаа хамруулан идэвхтэй хамтран ажиллана уу. Хуралд оролцох эрдэм шинжилгээний ажилтны нэрс, хэлэлцүүлэх илтгэлийн сэдэв, холбоо барих утас, мэйл хаягийг gulfira@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт: 5 хуудастай

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

С.МӨНХБАТ



D:/my doc/letter/ЭШБ-д

09 07987



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Партизаны гудамж, Утас: 26 35 64, Факс: (976-11) 32 49 77,
И-мэйл: doc@nema.mn, Вэбсайт: www.nema.mn

2019.06.13 № 2/1323

танай _____-ны № _____-т

Удирдамж хүргүүлэх тухай

Монгол Улсын бүх хот, аймгийн төвүүд хот суурин газрын гамшигт тэсвэрлэх чадварыг сайжруулахад чиглэсэн "Гамшигт тэсвэртэй хот" хөдөлгөөнд 2018 онд элсэн орсон. Нийгэм эдийн засгийн хөгжил, хотжилт эрчимтэй явагдаж буйтай холбоотойгоор хот суурин газруудын гамшигт тэсвэртэй байдлыг хангах, барилга, байгууламж, дэд бүтцийг илүү сайжруулан барьж байгуулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд онцгой анхаарал хандуулж, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч энэ нь хэрэгжих шатанд тулгамдсан олон асуудал бий болж байна.


Эдгээр асуудлыг шийдэхэд бүх талуудын мэдлэг, ойлголт, оролцоо, нэн ялангуяа шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн, судлаачдын үүрэг оролцоо онцгой чухал гэж үзэж Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэн, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль, НҮБ-ын Гамшигийн эрсдэлийг бууруулах газартай хамтран "Хот суурин газрын гамшигт тэсвэрлэх чадвар (resilience)-ыг бэхжүүлэх арга зам" сэдэвт олон улсын хурлыг 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Иймд, тус хуралд хот төлөвлөлт, хотын гамшигийн эрсдэлийг бууруулах чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийдэг эрдэмтэн судлаачид болон холбогдох мэргэжилтнийг оролцуулж, эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллахыг хүсье.

Хурлын удирдамжийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 4 хуудастай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

00001592



**“Хот суурин газрын гамшгийг тэсвэрлэх чадвар (Resilience)-ыг бэхжүүлэх арга зам” сэдэвт
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

Хугацаа
2019 оны 9 дүгээр сарын 27

Зохион байгуулагдах газар
Монгол Улс, Улаанбаатар хот, Бест вэстерн пример Туушин зочид буудал

Зохион байгуулагч
Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн

Хамтран зохион байгуулагч
Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль
НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах газар (UNISDR)

Үндэслэл

Монгол орны газарзүй болон нийгэм, эдийн засгийн өвөрмөц байдал нь гамшгийн эрсдэлийн онцгой нөхцлийг бүрдүүлж байдаг. Тухайлбал, манай улсад хүчтэй салхи, шуурга, үер, ой, хээрийн түймэр, ган, зуд зэрэг байгалийн аюулт үзэгдэл, объектын түймэр, цацраг, хими, үйлдвэрлэлийн зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотой осол жил бүр тохиолдож, хүн амын ахуй амьдрал, улс орны эдийн засаг, тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Үүний зэрэгцээ Монгол Улс нь төв Азийн газар хөдлөлтийн өндөр эрсдэлтэй бүс нутагт байрладаг бөгөөд сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн давтамж улам бүр нэмэгдэх боллоо. Иймээс гамшгийн эрсдэлийг бууруулах нь Монгол Улсын төр, засгийн бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн нэгд тооцогддог юм.

Монгол Улсын бүх хот, аймгийн төвүүд хот суурин газрын гамшгийг тэсвэрлэх чадварыг сайжруулахад чиглэсэн "Гамшигт тэсвэртэй хот хөдөлгөөн"-нд 2018 онд элсэн орсон нь Засгийн газрын түвшинд гамшигт тэсвэртэй хотыг бий болгох асуудлаар дээд түвшний манлайлал үзүүлж, ихээхэн анхаарал хандуулж байгаагийн илэрхийлэл гэж үзэж болно.

Нийгэм эдийн засгийн хөгжил, хотжилт эрчимтэй явагдаж буйтай холбоотойгоор хот суурин газруудын гамшигт тэсвэртэй байдлыг хангах, барилга, байгууламж, дэд бүтцийг илүү сайжруулан барьж байгуулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд төрийн зүгээс

онцгой анхаарал хандуулж тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч энэ нь хэрэгжих шатандаа олон асуудалтай тулгарч байна. Эдгээр асуудлыг шийдэхэд бүх талуудын мэдлэг, ойлголт, оролцоо, нэн ялангуяа шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн, судлаачдын үүрэг оролцоо онцгой чухал гэж үзэж энэ удаагийн хурлыг зохион байгуулж байна.

Зорилго

- Хот суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийг тэсвэрлэх чадварыг сайжруулахад шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын оролцоог нэмэгдүүлэх;
- Хот суурин газрын гамшгийг тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх талаарх бусад улс орны туршлага, сургамжаас суралцах;
- Шинжлэх ухаан технологийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрдэмтэн, судлаачдад мэдлэг, чадвар, туршлагаа харилцан солилцох боломжийг бүрдүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн

Энэхүү эрдэм шинжилгээний хурлаас дараах гол үр дүнг хүлээж байна. Үүнд:

- Хурлаас хот суурин газрын гамшгийг тэсвэрлэх чадварыг бэхжүүлэхэд шинжлэх ухааны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, шинжлэх ухаанд суурилсан бодлого, шийдвэрийг гаргах аргазүйн талаар багц зөвлөмж гарна.
- Хот суурин газрыг гамшигт тэсвэртэй төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын энэ талын мэдлэг, ойлголт нэмэгдэнэ.
- Байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг дээшлүүлэх арга замын талаар харилцан мэдлэг, туршлагаа хуваалцаж, талуудын хамтын ажиллагаа сайжирна.

Хэлэлцэх илтгэлийн чиглэл

1. Гамшгийн эрсдэлийн засаглал ба Гамшигт тэсвэртэй хот

- гамшгийн эрсдэлийн засаглал;
- гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа;
- гамшгийн эрсдэлийг бууруулах төр хувийн хэвшлийн түншлэл;
- гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийн үеийн удирдлага, зохицуулалт;
- гамшгийн аюулын зарлан мэдээллийн систем, хүн амд зарлан мэдээллийг түгээх арга зам;
- гамшгийн эрсдэлийн мэдээллийг газар ашиглалт, хот төлөвлөлт, хөгжлийн бодлого төлөвлөлтөд ашиглах нь;
- нэн чухал дэд бүтцийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшигт тэсвэртэй дэд бүтэц бий болгох төлөвлөлт, норм, дүрэм;
- гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө;

- гамшгийн эрсдэлийн санхүүжилт, даатгал, эрсдэлийн үнэлгээний дүнг хотын хөрөнгө оруулалтад тусгах асуудал;
- хот суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулахад зайнаас тандан судлал, газарзүйн мэдээллийн систем болон дэвшилтэт технологийн хэрэглээ;
- гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэлт, хэрэглээ, технологийн шийдэл;
- гамшгийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлтэй хамаарах барилгын норм, дүрэм, стандартыг боловсруулах, сайжруулах болон мөрдүүлэх;
- хот суурин газрын ногоон байгууламж, хот доторх байгалийн экосистемийг тогтоох, хамгаалах;
- орон нутгийн түвшинд гамшигт тэсвэртэй хотыг бий болгох чадавхыг бэхжүүлэх арга зам.

2. Газар хөдлөлт ба бусад байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал

- газар хөдлөлтийн идэвхжил, хагарал;
- газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ;
- газар хөдлөлт болон бусад байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг дээшлүүлэх арга зам;
- газар хөдлөлтөд тэсвэртэй барилга, байгууламж, нэн чухал дэд бүтэц.

3. Гал түймэр болон бусад хүний үйл ажиллагаатай холбоотой ослоос урьдчилан сэргийлэх нь

- хүн амд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар олгох сургалт, сурталчилгаа;
- объектын гал түймрийн эрсдэлийг бууруулах арга зам;
- бусад хүний үйл ажиллагаатай холбоотой ослоос урьдчилан сэргийлэхэд шинжлэх ухаан, технологийн хэрэглээ;
- галын аюулгүй байдлыг хангах дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, стандарт, норм, дүрэм;

Оролцогчдын хамрах хүрээ

Гамшгийн эрсдэлийг бууруулах, хот суурин газрын гамшгийг тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх чиглэлээр судалгаа хийдэг гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачид, төрийн байгууллагын бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүд.

Эрдэм шинжилгээний өгүүлэл ирүүлэх хугацаа

Оролцогчид эрдэм шинжилгээний өгүүллээ 2019 оны 8 дугаар сарын 10-ны дотор Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнд ирүүлнэ.

Холбоо барих, илтгэл ирүүлэх хаяг: Утас: 99105587, 89039012. Цахим шуудан: nema.dri.mn@gmail.com

Ирүүлсэн бүтээлийг Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн, шалгаруулж эрдэм шинжилгээний хуралд оролцох, эмхэтгэлд хэвлүүлэх, илтгэл хэлэлцүүлэх гэсэн хэлбэрүүдээр оролцуулна. Шалгарсан бүтээлийг урьдчилан мэдэгдэнэ.

Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага:

Өгүүллийг А4 хэмжээтэй цаасанд 12 хуудаст багтаан дараах форматаар бичиж ирүүлнэ.

- Хэрэглээний программ: Microsoft Word
- Үсгийн фонд: Arial
- Бичвэрийн өндөр: 12
- Мөр хоорондын зай: 1.15
- Бичвэрийн тохиргоо: Дээр-1.5см, доор-2см, зүүн-3см, баруун-1.5см
- Өгүүллийг хэвлэмэл болон цахимаар ирүүлэх ба зохиогчийн зураг, товч танилцуулгыг хавсаргана.
- Зохиогчийн эрдмийн зэрэг, цол, цэргийн цол, албан тушаал, илтгэлийн сэдэв, хураангуй, түлхүүр үгсийг англи, монгол хэл дээр бичсэн байна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГАМШИГ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН